



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



2026 I

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



www.1212.mn

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2022-2026 он	3
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	3
I	Эрүүл мэнд	5
II	Нийгмийн даатгал	8
III	Нийгмийн халамж	11
IV	Гэмт хэрэг	12
V	Дүүргийн төсөв	15
VI	Хэрэглээний үнэ	18
VII	Цаг уур, агаарын бохирдол, аюулт үзэгдэл	22
VIII	Хөдөө аж ахуй	24
IX	Захиргааны мэдээ	25

ХҮСНЭГТ 1. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 I	2023 I	2024 I	2025 I	2026 I	
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	320 ↓8.3	407 ↑27.2	382 ↓6.1	397 ↑3.9	358 ↓9.8	
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	17 075 ↑258.7*	197 ↓98.8	160 ↓18.8	172 ↑7.5	215 ↑25.0	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	300 ↑81.8	349 ↑16.3	398 ↑14.0	622 ↑56.3	710 ↑14.1	
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)	Хувь	2.3 ↑1.6	1.1 ↓1.2	0.7 ↓0.4	0.7 ↑0.6	0.9 ↓0.4	
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	2 849 ⁰⁰	3 467 ↑21.7	3 407 ↓1.7	3 432 ↑0.7	3 561 ↑3.8
	Юань (БНХАУ)	Төгрөг	448 ↑1.6	510 ↑13.8	475 ↓6.9	470 ↓1.1	511 ↑8.7
	Рубль (ОХУ)	Төгрөг	37 ↓2.6	50 ↑35.1	38 ↓24.0	34 ↓10.5	46 ↑35.3
Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	4.4 ↓43.0	20.1 ↑4.5*	32.8 ↑63.2	39.1 ↑19.2	31.8 ↓18.7	
Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум Төгрөг	1.8 ↓59.5	1.4 ↓22.2	4.3 ↑31.1*	4.8 ↑11.6	4.7 ↓2.1	
Агаарын дундаж температур	°C	-20.9	-17.4	-21.0	-19.1	-4.1	

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 I						2026 I					
		Хотын дундаж	Хамгийн өндөр			Хамгийн бага			Хотын дундаж	Хамгийн өндөр			Хамгийн бага
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	357	Баянгол	8 797	Налайх	59	357	Баянгол	8 797	Налайх	59		
			Чингэлтэй	1 490	Багануур	47		Чингэлтэй	1 490	Багануур	47		
			Сүхбаатар	688	Багахангай	32		Сүхбаатар	688	Багахангай	32		
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	18	Чингэлтэй	25	Налайх	-	15	Багахангай	21	Хан-Уул	6		
			Сонгино-хайрхан	20	Багануур	-		Баянзүрх	19	Багануур	0		
			Сүхбаатар	18	Багахангай	-		Сүхбаатар	15	Багахангай	0		
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	11	Баянзүрх	13	Багануур	6	12	Баянзүрх	11	Сонгино-хайрхан	7		
			Сүхбаатар	10	Налайх	3		Багануур	9	налайх	4		
			Чингэлтэй	9	Багахангай	2		Чингэлтэй	8	Багахангай	0		
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	47	Баянгол	104	Багахангай	82	134	Хан-Уул	548	Чингэлтэй	54		
			Сүхбаатар	102	Налайх	75		Баянзүрх	323	Багахангай	28		
			Чингэлтэй	102	Багануур	29		Сүхбаатар	286	Налайх	26		
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	38	Сүхбаатар	61	Сонгино-хайрхан	26	38	Сүхбаатар	63	Сонгино-хайрхан	25		
			Чингэлтэй	52	Багахангай	10		Чингэлтэй	56	Налайх	17		
			Баянзүрх	40	Багануур	10		Хан-Уул	41	Баганхангай	13		

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м

Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII

Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй

* урьдчилсан гүйцэтгэл

** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/ Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрүм	=10 ⁹
их наяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД

2026 оны 1 сард 354 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 38(9.7%) төрөлтөөр буурсан байна.


Дүүргийн хэмжээнд 2026 оны 1 сард 354 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 38 (9.7%) төрөлтөөр буурсан байна. 2026 оны 1 сард

нялхсын эндэгдэл 4 хүүхдээр буурсан бол 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, эхийн эндэгдэл гараагүй байна.

ХҮСНЭГТ 3. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, ЖИЛ БҮРИЙН I САРД

Үзүүлэлт	2024 I	2025 I	2026 I	Өөрчлөлт %
Амаржсан эхийн тоо	379	392	354	-9.7
Амьд төрсөн хүүхэд	382	397	358	-9.8
Эхийн эндэгдэл	0	0	0	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	3	6	2	-66.7
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1	0	0	-

ЗУРАГ 1. АМАРЖСАН ЭХ, АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД



Дүүргийн хэмжээнд 2026 оны 1 дүгээр сарын байдлаар 215 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 43 (25.0%) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 1.2 продицимилээр өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 33.9 хувийг салхин цэцэг,

2.3 хувийг гар хөл, амны өвчин, 1.9 хувийг цусан суулга, 2.8 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 7.4 хувийг тэмбүү, 3.3 хувийг заг хүйтэн, 20.5 хувийг улаан бурхан, 27.9 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.

ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн I сард

Төрөл	Хэмжих нэгж	2024 I	2025 I	2026 I	Өөрчлөлт	
					тоо/нэгж	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	тоо	160	172	215	43	25.0
	10000 хүнд	7.9	6.9	8.1	1.2	
Үүнээс:						
Вируст гепатит	тоо	1	3	1	2	-66.7
	10000 хүнд	0.0	0.1	0.0	-0.1	
Цусан суулга	тоо	13	8	4	-4	-50.0
	10000 хүнд	0.6	0.3	0.2	-0.1	
Улаан эсэргэнэ	тоо	15	2	12	10	6.0**
	10000 хүнд	0.7	0.1	0.5	0.4	
Сальмонеллөз	тоо	0	1	2	1	2.0**
	10000 хүнд	-	0.0	0.1	0.1	
Салхин цэцэг	тоо	81	133	73	-60	-45.1
	10000 хүнд	4.0	5.4	2.7	-2.7	
Гахайн хавдар	тоо	2	0	0	-	-
	10000 хүнд	0.1	-	-	-	
Ёлом	тоо	3	1	4	3	4.0**
	10000 хүнд	0.1	0.0	0.2	0.2	
Гар хөл, амны өвчин	тоо	9	1	5	4	5.0**
	10000 хүнд	0.4	0.0	0.2	0.2	
Тэмбүү	тоо	11	7	16	9	2.3**
	10000 хүнд	0.5	0.3	0.6	0.3	
Заг хүйтэн	тоо	5	5	7	2	40.0
	10000 хүнд	0.2	0.2	0.3	0.1	
Трихомониаз	тоо	1	0	1	1	100.0
	10000 хүнд	0.0	0.0	0.0	-	
Сүрьеэ	тоо	17	7	6	-1	-14.3
	10000 хүнд	0.8	0.3	0.2	-0.1	
Улаан бурхан	тоо	0	0	44	44	100.0
	10000 хүнд	0.0	0.0	1.7	1.7	
Коронавирус – (Covid 19)	тоо	0	0	0	-	-
	10000 хүнд	-	-	-	-	
Бусад	тоо	2	4	40	36	10.0**
	10000 хүнд	0.1	0.2	1.4	1.2	

ЗУРАГ 2. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД



Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн

хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт

болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



НИЙГМИЙН ДААТГАЛ

Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын орлого 49.4 тэрбум төгрөг хүрч төлөвлөсөн хэмжээг бүрэн ханган ажиллалаа.

2026 оны 1 дүгээр сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 49.4 тэрбум төгрөг хүрч төлөвлөсөн хэмжээг бүрэн ханган ажиллалаа.

2026 оны 1 дүгээр сард орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 5.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан тус бүрээр, 2026 оны I сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт	
	2025 I	2026 I	2025 I	2026 I	Хувь	
Нийт дүн	41 686.2	49 363.1	40 178.0	49 379.6	-3.6	0.1
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	35 267.3	40 809.6	32 649.6	40 659.1	-7.4	-0.4
Тэтгэмжийн сангийн орлого	3 160.9	4 296.3	3 420.9	4 307.2	8.2	0.3
ҮОМШӨ-ний даатгалын орлого	2 053.8	2 690.3	2 910.9	2 899.6	41.7	7.8
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	1 204.2	1 566.9	1 196.6	1 513.7	-0.6	-3.4


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 82.3 хувийг тэтгэврийн даатгалын санд, 8.7 хувийг тэтгэмжийн

даатгалын санд, 5.9 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 3.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.


ЗУРАГ 3.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ДААТГАЛЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 4.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар



Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 23823 хүнд 27.2 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3391 хүнд 2.5 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 1160 хүнд 896.2 сая төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1675 хүнд 2.9 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 880 хүнд 365.5 сая төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 385 хүнд 2.08 тэрбум төгрөгийг, 80 хүнд оршуулгын тэтгэмж 240 сая төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 141 хүнд 163.2 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 17 хүнд 23.5 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 17 хүнд 38.2 сая төгрөгийг тус тус олгосон байна. ҮОМШӨ-ний бусад зардалд 14 хүнд 11.7 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1241 хүнд 9.03 тэрбум төгрөг зарцуулжээ.

Мөн ажил олгогч даатгуулагч, олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээнд 341 мянган төгрөг зарцуулсан байна.

ЗУРАГ 5.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



ЗУРАГ 6.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО



Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



ХАЛАМЖ

2026 оны 1 дүгээр сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн зарлагын 10.2 (69.7%) тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгө буюу 101815 хүнд, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 0.5 (3.6%) тэрбум төгрөг,

нийгмийн халамж 3.9 (26.6%) тэрбум төгрөг, хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 3.2 (0.02%) сая төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт 8.8 (0.1%) саяыг тус тус зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 6.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая төгрөг

Үзүүлэлт	2026 I	
	Дүн	Хүний тоо
Нийт зарлагын дүн	14 653.9	122 221
Нийгмийн халамжийн сан	3 900.8	9 698
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	521.7	10 432
Алдарт эхийн одонгийн тусламж	0	0
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	8.8	48
Хүүхдийн мөнгө	10 219.4	101 815
Насны хишиг	0	0
Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	0	0
Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	3.2	228

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн халамж гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн" гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.



ГЭМТ ХЭРЭГ

2026 оны 1 дүгээр сард дүүргийн нутаг дэвсгэрт 710 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй

харьцуулахад 88(14.1%) хэргээр өссөн үзүүлэлттэй байна.


ХҮСНЭГТ 7. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, 2026 оны I сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2024 I	2025 I	2026 I	Тоо	Хувь
Дүүргийн дүн	398	622	710	88	14.1
Хүний амь	-	-	2	2	-
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	13	11	14	3	27.3
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	60	77	105	28	36.4
Хүчин	9	8	10	2	25.0
Хулгай	90	109	135	26	23.9
Малын хулгай	-	1	1	0	100.0
Дээрэм	8	6	9	3	50.0
Залилан	134	268	295	27	10.1
Олон нийтийн амгалан тайван байдал	-	-	-	-	-
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	5	25	18	-7	-28.0
Бусад	79	117	121	4	3.4

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 41.5 хувийг залилан, 14.8 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 19.1 хувийг хулгай, 2.5 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын

журам зөрчих, 1.4 хувийг хүчин, 1.3 хувийг дээрэм, 2.0 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 0.3 хувийг хүнийг амь, 0.1 хувийг малын хулгай, 17.0 хувийг бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ

Хэлтэс	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг			Өөрчлөлт 2025/2024	
	2024 I	2025 I	2026 I	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	2 886	4 110	4 160	50	1.2
Хан-Уул дүүргийн дүн Үүнээс: Цагдаагийн хэлтсээр	398	622	710	88	14.1
I хэлтэс	220	394	457	63	16.0
II хэлтэс	178	228	253	25	11.0
Нийслэлийн дүнд эзлэх хувь	13.8	15.1	17.1	76.0	2.0

Дүүргийн хэмжээнд 2026 оны 1 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн нийслэлийн дүнд эзлэх хувь 17.1 байгаа нь өмнөх оны мөн үетэй 2.0 нэгж хувиар өссөн

байна. Түүнчлэн дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 64.4 хувь нь цагдаагийн I хэлтсийн харьяа хороодын нутаг дэвсгэрт үйлдэгджээ.

ХҮСНЭГТ 9. ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ, хэлтсээр

Хэлтэс	Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг		Эмэгтэй хүн оролцсон		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	
	2025 I	2026 I	2025 I	2026 I	2025 I	2026 I
Дүүргийн дүн	26	30	7	113	16	13
I хэлтэс	11	22	5	85	9	8
II хэлтэс	15	8	2	28	7	5

Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт 2026 оны 1 дүгээр сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас 13 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 3(18.7%) хэргээр буурсан байна. Дүүргийн хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон 658 иргэн хохирсоны 323(49.1%) нь эмэгтэйчүүд байсан бол 1 (0.2%) нь 7 хүртэлх насны хүүхэд, 13(2.0%) нь 8-13 насны хүүхэд, 6(0.9%) нь 14-17 насны хүүхдүүд хохирсон байна.

Гэмт хэргийн улмаас 108 хүн гэмтэж осолдон, 10 хүн нас барж, төр, ард иргэдэд 95.7 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 6.2(6.5%) тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

2026 оны 1 дүгээр сарын байдлаар тус дүүргийн 15 дугаар хороонд 120 гэмт хэрэг гарч хамгийн өндөр, 7 болон 13 хороодын нутаг дэвсгэрт хамгийн бага буюу 3 гэмт хэрэг гарсан байна.

ХҮСНЭГТ 10. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, төрлөөр

Хороо	Нийт дүн	Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Хүчин	Хулгай	Үүнээс			Дээрэм	Залилан	Малын хулгай	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	Бусад
							ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай					
Нийт дүн	710	2	14	105	10	135	100		9	9	295	1	18	121
1-р хороо	31		1	7	2	3	1				13			5
2-р хороо	23			6		2	1		1	1	11			3
3-р хороо	53		1	3	1	8	8		1	1	27		4	8
4-р хороо	15			2		4	3				2		3	4
5-р хороо	13		1	3		1	1				6			2
6-р хороо	9			2		3	1				4			0
7-р хороо	3		1	1		0					1			0
8-р хороо	26		1	5		6	3		1	1	7		1	5
9-р хороо	6		1	2		2	1				0			1
10-р хороо	10			2		4	2				3			1
11-р хороо	55		1	8	1	5	5		1	1	22			17
12-р хороо	5		1	2		1	1				1			
13-р хороо	3				1	0					2			
14-р хороо	8	2		1		1					1	1		2
15-р хороо	120		1	21	1	33	24				48		2	14
16-р хороо	10			3		4	4				3			
17-р хороо	41			3	2	7	6				22			7
18-р хороо	27		1	6	1	7	7				9		1	2
19-р хороо	30		1	2		1	1				17		1	8
20-р хороо	67		1	6	1	8	8		4	4	28			19
21-р хороо	43		1	2		16	10		1	1	15		3	5
22-р хороо	10		1	2							6			1
23-р хороо	54			9		10	8				24		2	9
24-р хороо	33			7		7	3				13		1	5
25-р хороо	15					2	2				10			3




ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого 31.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 24.8 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2026 оны I сард 31.8 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 24.8(43.8%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2025 оноос 41.8 хувиар өссөн байна. Төсвийн нийт

орлогын 96.9 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 3.1 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого, улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг) эзэлж байна.

ЗУРАГ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



Татварын орлогын хэмжээ 30.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 25.2(45.0%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бол татварын бус

орлого 976.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 396.1(68.2%) сая төгрөгөөр илүү бүрдсэн байна.

ХҮСНЭГТ 11.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны I сард

	Төсвийн орлого			Үүнээс					
				Татварын орлого			Татварын бус орлого		
	Бүгд	ТБ %	Зөрүү	Бүгд	ТБ %	Зөрүү	Бүгд	ТБ %	Зөрүү
	сая төгрөг								
Дүн	31 854.8	-43.8	-24 835.8	30 878.2	-45.0	-25 231.8	976.6	68.2	396.1

Орлогын албан татвар төлөвлөснөөс 17.5 тэрбум төгрөгөөр, бусад татвар, төлбөр,

хураамж төлөвлөснөөс 6.8 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 962.9 сая төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.


ХҮСНЭГТ 12.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны I сард

Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Өөрчлөлт	
	сая төгрөг		Хувь	Дүн
Орон нутгийн орлого	56 690.6	31 854.8	-43.8	-24 835.8
1.Татварын орлогын дүн	56 110.1	30 878.2	-45.0	-25 231.8
1.1 Орлогын албан татвар	43 241.5	25 756.9	-40.4	-17 484.6
Хувь хүний орлогын албан татвар	43 241.5	25 756.9	-40.4	-17 484.6
1.2 Хөрөнгийн албан татвар	3 629.9	2 667.0	-26.5	-962.9
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	9 238.7	2 454.3	-73.4	-6 784.4
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	3 216.1	1 291.3	-59.8	-1 924.8
Улсын тэмдэгтийн хураамж	2 400.0	1 038.9	-56.7	-1 361.1
Ашигт малтмал ашигласны төлбөр	40.0	0.0	-100.0	-40.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	776.1	252.4	-67.5	-523.7
1.3.2 Газрын төлбөр	5 978.6	1 135.9	-81.0	-4 842.7
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	44.0	27.1	-38.3	-16.9
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	44.0	27.1	5.8**	23.1
2.Татварын бус орлогын дүн	580.5	976.6	68.2	396.1
2.1 Нийтлэг татварын бус орлого	580.5	976.6	68.2	396.1
Торгуулийн орлого	500.0	942.8	88.6	442.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого*	76.5	33.5	-56.2	-43.0
Бусад орлого	4.0	0.3	-91.2	-3.7
2.2 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0

ЗУРАГ 9.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг



ХҮСНЭГТ 13.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2026 оны I сард, сая төгрөг

Үзүүлэлт	Зарлага		Өөрчлөлт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Дүн
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	57 083.4	4 712.4	-91.7	-52 371.0
1. Урсгал зарлага	51 116.7	4 711.3	-90.8	-46 405.4
1.1 Бараа, үйлчилгээний зардал	13 331.8	4 711.3	-64.7	-8 620.5
Цалин хөлс	1 785.9	1 165.8	-34.7	-620.1
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	225.4	128.8	-42.9	-96.6
Бараа, үйлчилгээний бусад зардал	11 320.5	3 416.7	-30.2	-7 903.8
1.2 Татаас ба урсгал шилжүүлэг	37 784.9	0.0	-100.0	-37 784.9
Татаас	-	-	-	-
Урсгал шилжүүлэг	37 784.9	0.0	-100.0	-37 784.9
2. Хөрөнгийн зардал	5 966.7	1.1	-100.0	-5 965.6
Барилга байгууламж	2 806.3	0.0	-100.0	-2 806.3
Их засвар	2 092.5	0.0	-100.0	-2 092.5
Тоног төхөөрөмж	348.7	0.0	-100.0	-348.7
Бусад хөрөнгө	719.2	1.1	-99.8	-718.1

Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн

сарын эхэнд үлдэгдэлгүй байсан бол шинээр өглөг үүсээгүй байна.

ХҮСНЭГТ 14.

ӨГЛӨГ, 2026 оны I сард

	1-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	1-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	0.0	0.0	0.0	0.0

Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өссөн байна.

Нийслэлийн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс 2026 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 7.5 хувь, өмнөх сараас 0.9 хувиар өссөн байна

ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний үнийн индекс 2026 оны 1 дүгээр сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 0.9 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 3.0 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах

бодис бүлгийн үнэ 2.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 1.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна

ХҮСНЭГТ 15. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2024-I	2025-I	2026-I	2026-I
	2023-I	2024-I	2025-I	2025-XII
Хувь				
Ерөнхий индекс	8.2	9.7	7.5	0.9
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	12.2	8.7	13.0	3.0
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	4.0	4.0	11.2	2.0
Хувцас, бөс бараа, гутал	5.9	10.7	6.7	0.3
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	5.2	24.3	5.5	-0.4
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	6.7	11.9	5.3	0.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	8.3	5.4	7.7	1.8
Тээвэр	0.0	2.7	0.1	-0.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.3	1.7	2.5	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.5	6.1	6.6	0.0
Боловсролын үйлчилгээ	21.2	19.7	13.6	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	15.7	14.3	7.0	1.3
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	2.3	13.5	1.7	0.0
Бусад бараа, үйлчилгээ	20.4	10.3	9.7	0.0

2026 оны 1 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 418 төрлийн бараа, үйлчилгээний үнийг өмнөх сартай харьцуулахад 134 (32.0%) бараа үйлчилгээний үнэ өсөж, 37 (8.9%) бараа үйлчилгээний үнэ буурч, 247 (59.1%) бараа үйлчилгээний үнэ тогтвортой байв.

2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний сонгогдсон 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад “Үхрийн мах”, ястай мах 6000 төгрөг, польш алим 3500 төгрөг, “Хонины мах”, ястай 3000 төгрөг, төмс 1900 төгрөг, сонгино тус бүр 1500 төгрөг, манжин 500 төгрөг,


дээд зэргийн гурил 400 төгрөг, тараг, “Сүү” ХК-ийн цөцгийтэй тараг 380 төгрөг, цагаан будаа 300 төгрөгөөр, задгай сүү 200 төгрөг, 2-р зэргийн гурил 161 төгрөг, 1-р зэргийн гурил 140 төгрөг, Талх чихэр” ХК-ны “Атар” талх 120 төгрөгөөр тус тус өссөн бол, элсэн чихэр 700 төгрөгөөр буурсан байна. Харин байцаа болон луувангийн үнэ тогтвортой байна

ХҮСНЭГТ 16. БАРААНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн 1 дүгээр сард


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2025 I	2026 I	Хувь
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	ширхэг	2 760	2 880	4.3
Хонины мах, ястай	кг	14 500	17 500	20.7
Үхрийн мах, ястай	кг	18 500	24 500	32.4
Гурил , дээд зэрэг, “Алтан тариа” ХК, савласан	кг	3 250	3 650	12.3
Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа” ХК, задгай	кг	2 660	2 800	5.3
Гурил ,2-р зэрэг, “Алтан тариа” ХК, савласан	кг	1 889	2 050	8.5
Элсэн чихэр	кг	10 000	9 300	-7.0
Төмс, монгол	кг	1 400	3 300	2.3**
Байцай, монгол	кг	2 800	2 800	0.0
Лууван, монгол	кг	3 000	3 000	0.0
Манжин, монгол	кг	4 500	5 000	11.1
Сонгино, хятад	кг	3 500	5 000	42.9
Цагаан будаа	кг	6 100	6 400	4.9
Алим, Польш	кг	8 000	11 500	43.8
Сүү, задгай	литр	4 100	4 300	4.9
Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК	литр	4 370	4 750	8.7

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсүврага” төв


ЗУРАГ 11. НЭГ КИЛОГРАММ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн I сард, төгрөг



ЗУРАГ 12. НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн I сард, төгрөг



ЗУРАГ 13. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн I сард, төгрөг



ХҮСНЭГТ 17. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, төгрөг

ШТС	2025.I.19					2026.I.20				
	Аи 95	Аи 80	и 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Дундаж үнэ	3 910	-	2 390	3 140	1 950	3 643	-	2 590	3 140	1 950
Петровис	3 910	-	2 390	3 140	-	3 610	-	2 590	3 140	-
Магнай трейд	3 910	-	2 390	3 140	-	3 710	-	2 590	3140	-
Шунхлай	3 910	-	2 390	3 140	-	3 610	-	2 590	3140	-
Юнигаз	-	-	-	-	1 950	-	-	-	-	1 950

Эх үүсвэр: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 1 дүгээр сарын мэдээ

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

- I_{ct}^L – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс
- t – Тайлант үе
- 0 – суурь үе
- P_t^i – i барааны тайлант үеийн үнэ
- P_0^i – i барааны тайлант үеийн үнэ
- q_0^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.



ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэлийн агаарын дундаж хэм 2026 оны 1 дүгээр сард -4.1 °C байв.

Нийслэлийн агаарын дундаж хэм 2026 оны 01 дүгээр сард -4.1 °C байгаа нь өмнөх оны мөн үеийн дундажтай харьцуулбал 13.3°C-аар дулаан байв. Энэ

сарын хур тунадасны нийлбэр 10.1 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 18 метр секунд хүрсэн байна.

ХҮСНЭГТ 18.

АГААРЫН БОХИРДОЛТ, I сард

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий, мг/м ³	SO ₂	0.050	440	0.271	138	0.047
Азотын давхар исэл, мг/м ³	NO ₂	0.050	427	0.100	263	0.052
Тоосжилт, мг/м ³	PM ₁₀	0.100	513	0.283	184	0.091
	PM _{2.5}	0.050	490	0.386	356	0.068
Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м ³	CO	10.000	369	9.600	79	2.288
Озон, мг/м ³	O ₃	0.100	864	0.093	0	0.023

2026 оны 01 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад азотын давхар исэл

4 мкг/м³ -ээр (7.0%), PM 10 тоосонцор 35 мкг/м³ -ээр (27.0%), PM 2.5 тоосонцор 17 мкг/м³ -ээр(19.0%), хүхэрлэг хий 77 мкг/м³-ээр (19.0%) тус тус бага байна.

ХҮСНЭГТ 19. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ХОНОГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, мг/м3, I сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл Экспо төв			Бөгд хааны ордон музей			Нисэх		
		2023	2024	2026	2024	2025	2026	2024	2025	2026
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.071	0.050	0.043	0.032	0.072	0.038	-	-	-
	Хамгийн их	0.186	0.100	0.128	0.086	0.122	0.116	-	-	-
	XXX*-с давсан %	79	45	26	3	77	29	-	-	-
	Хэмжилтийн тоо	29	31	31	31	31	28	-	-	-
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	-	0.036	0.021	0.045	0.045	0.046	0.061	0.056	-
	Хамгийн их	-	0.107	0.064	0.060	0.063	0.064	0.088	0.099	-
	XXX*-с давсан %	-	32	10	26	32	33	71	54	-
	Хэмжилтийн тоо	-	31	31	31	31	24	31	24	-
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	1.234	0.472	0.912	0.653	0.673	0.961	1.855	2.014	1.885
	Хамгийн их	4.276	2.542	4	1.411	1.758	1.679	4.315	4.976	2.89
	XXX*-с давсан %	-	-	-	-	-	-	2	-	-
	Хэмжилтийн тоо	93	93	31	93	93	27	93	83	31
Тоос PM ₁₀	Дундаж	0.068	0.086	0.063	0.056	0.067	0.05	0.071	0.07	0.035
	Хамгийн их	0.135	0.186	0.143	0.098	0.147	0.094	0.110	0.115	0.061
	XXX*-с давсан %	13	35	13	0	16	0	16	23	-
	Хэмжилтийн тоо	31	31	31	31	31	31	31	31	31
Тоос PM _{2.5}	Дундаж	-	0.057	0.02	0.033	0.036	0.026	0.060	0.062	0.029
	Хамгийн их	-	0.138	0.041	0.068	0.090	0.056	0.095	0.108	0.047
	XXX*-с давсан %	-	45	3	13	26	24	68	68	29
	Хэмжилтийн тоо	-	31	30	31	31	25	31	31	31
Озон O ₃ **	Дундаж	0.023	0.022	0.025	-	-	-	0.026	0.024	0.025
	Хамгийн их	0.054	0.050	0.049	-	-	-	0.080	0.087	0.075
	XXX*-с давсан %	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	93	93	93	-	-	-	93	-	46

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний 1 сард 24 толгой том мал зүй бусаар хорогдсон байна.


Дүүргийн хэмжээнд 2026 оны 1 сард 24 толгой том мал зүй бусаар хорогдож, том малын зүй бус хорогдлын 4 (16.7%) нь хээлтэгч мал байна.

Хорогдсон нийт малын 33.3 хувийг адуу, 12.5 хувийг үхэр, 8.4 хувийг хонь, 45.8 хувийг ямаа эзэлж байна.

ХҮСНЭГТ 20. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, хороогоор

Төрөл	2023 I		2024 I		2025 I		2026 I	
	Хорогдсон мал	Хээлтэгч	Хорогдсон мал	Хээлтэгч	Хорогдсон мал	Хээлтэгч	Хорогдсон мал	Хээлтэгч
Дүүргийн дүн	37	5	184	23	5	1	24	4
12-р хороо	19	2	30	3	-	-	-	-
13-р хороо	9	2	104	17	2	-	8	2
14-р хороо	9	1	50	3	3	1	16	2

ХҮСНЭГТ 14. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН МЭДЭЭ, сараар



ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2026 оны 1 дүгээр сард Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт иргэдээс 220 өргөдөл, гомдол ирүүлснээс 145 (65.9%)-ийг шийдвэрлэн

хуулийн дагуу хугацаанд хариу өгч, шийдвэрлэх хугацаа болоогүй 75(34.1%) өргөдөл гомдол байна.

ХҮСНЭГТ 21. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ-ЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

Өргөдөл, гомдлын агуулга	Өргөдөл гомдлын тоо	АГУУЛГА					Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Хүсэлт	Гомдол	Талархал	Санал	Мэдэгдэл			
НИЙТ ДҮН	220	145	60	12	3	0	145	75	0
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	2	1		1			2		
Санхүү төрийн сангийн хэлтэс									
Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	7	5	2				2	5	
Нийгмийн хөгжлийн хэлтэс	1	1						1	
Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	17	12	5				13	4	
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	11	2	8		1		8	3	
Хууль, эрх зүйн хэлтэс	5	3	2				3	2	
Архивын хэлтэс									
Цэргийн штаб									
ЗДТГ-ын дүн	43	24	17	1	1	0	28	15	0
Насан туршийн суралцахуйн төв	1	1					1		
Боловсролын хэлтэс	11	3	7	1			9	2	
Газар зохион байгуулалтын алба	69	56	11		2		53	16	
Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс	7	7					4	3	
Нийгмийн даатгалын газар	4	2	2				3	1	
Татварын хэлтэс	41	41					16	25	
Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс	12	9	2	1			11	1	
Цагдаагийн 1-р хэлтэс	20	2	12	6			14	6	
Цагдаагийн 2-р хэлтэс	12		9	3			6	6	
Дэргэдэх хэлтэс, албадын дүн	177	121	43	11	2	0	117	60	0

БҮЛЭГ

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2021-2025 он	
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	
I	Эрүүл мэнд	Ц.Энх-Оюун
II	Нийгмийн даатгал	Т.Баттулга
III	Нийгмийн халамж	Т.Баттулга
IV	Гэмт хэрэг	Б.Тодмаа
V	Төсөв	Ж.Энх-Амгалан
VI	Хэрэглээний үнэ	Ж.Энх-Амгалан
VII	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	Б.Тодмаа
VIII	Хөдөө аж ахуй	Ц.Энх-Оюун
IX	Захиргааны мэдээ	Б.Тодмаа